

Увс аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015 оны жилийн ажлын тайлан

2015.12.08

Улаангом

Увс аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2015 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх үр дүнг танилцуулж байна.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Ажлын төлөвлөлт: 2015 онд аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох хууль, дүрэм, журмыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл хүргэх зэрэг арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллахыг зорилоо.

ГХУСАЗСЗ нь 2015 онд нийт 24 ажил, арга хэмжээг жилээр төлөвлөснөөс 22ажил хийгдэж жилийн ажлын гүйцэтгэл 91.6 хувийн биелэлттэй байна. Хийгдээгүй үлдсэн ажил арга хэмжээ нь холбогдох төсөв хөрөнгийн асуудал дутагдалтайн улмаас хэрэгжээгүй болно.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2015 онд дэвшүүлсэн зорилтот ажлын дагуу шүүх, прокурор болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран 3 удаагийн томоохон зөвлөгөөнийг зохион байгуулж “Гэр бүлийн хүчирхийлэл, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал”-ын талаар тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх талаар 2 зөвлөмж гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зөвлөмжийн мөрөөр гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг 5500 иргэд олон нийтэд мэдээллийн хэрэгсэл, гарын авлага, шторк, кейс, зурагт хуудас хэлбэрээр хууль сурталчлах сургалт сурталчилгааны ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа.



Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээг хэрэгжүүлж ажиллаж байна.

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн болон ОХУ-ын Тува Улсын Дээд Хуралд талуудын Хил Хамгаалах болон Цагдаагийн байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хагас жил тутам мэдээлэл бэлтгэж, харилцан солилцох, Цагдаа, Тагнуул, хууль хяналтын байгууллагууд хил дамнасан малын хулгайн зөрчилд холбогдож байсан болон холбогдож болзошгүй иргэдийн байрлал, тэдгээрийн үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавих, харилцан мэдээлэл солилцон ажиллаж байна.

Талууд үйл ажиллагаандаа Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээг удирдлага болгон найрамдал хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан уламжлалт харилцааг хөгжүүлэх зэрэг харилцан хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллах чиглэлийг тусгаж өгсөн нь цаашид шүүх эрх мэдлийн байгууллага болон хууль сахиулах байгууллагууд хамтран ажиллаж тодорхой үр нөлөөтэй ажлыг зохион байгуулан ажиллахад дөхөм болж байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСэргийлэх төлөвлөгөөт ажлын дагуу иргэдийн



аюулгүй байдлыг хангах, аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Прокурор, Шүүх, Хил 0245-р анги, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газраас хамтарсан баг, бүрэлдэхүүн 18 суманд хүрч ГХУСАЗСЗ-тэйгэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр нөлөөтэй ажил зохион байгуулж ажиллахаар хамтарч ажиллаа.

Энэхүү хамтын ажиллагааг орон нутгийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, ялангуяа 2014 онд өндөр үзүүлэлттэй гарсан гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт насанд хүрээгүй хүүхдийг өртүүлэхгүй байх түүнээс урьдчилан сэргийлэх талаар иргэд хөдөлмөрчдөд холбогдох хууль сурталчлах, яриа таниулга хийхээс гадна сумын ГХУАЗСЗ, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд энэ чиглэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай арга зүйн зөвлөмж өгч ажилласан нь тодорхой үр дүнгээ үзүүллээ.

Түүнчлэн дээрх сумдад ажиллахдаа илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 2015 оны 02 дугаар улирлын байдлаар аймгийн Прокурор, Цагдаагийн газраас 160 албан мэдэгдэл, 338 шаардлагыг бичиж хариуг нь хуулийн хугацаанд хүлээн биелэлт үр дүнг нь тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллаа.

Хууль зүйн сайдын 2014.06.08-ны өдрийн А/89 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь “Иргэний зөвлөл оршин суугчдад тайлан тавих журам”-ын дагуу Цагдаагийн газраас 2014 онд хийсэн ажлын, 2015 оны 1,2,3-р улирлын тайланг орон нутгийн САМА телевизээр 2015.01.31-ний өдөр иргэд олон нийтэд тайлагнаж, шууд утсаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллаа.

Аймгийн ИТХ-аас орон нутгийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх

сургалт, сурталчилгаа явуулах, байгууллага, аж ахуйн нэгжийг камержуулах тухай, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар хамтран ажиллах мэдээлэл солилцох журам, гэр бүлийн хүчирхийллийг эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэдийн гомдлын мөрөөр шалгалт хийх ажлын хэсэг байгуулах, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, урамшуулах гэх мэт 17 тогтоол шийдвэрийг баталж, сумын хэмжээнд хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна.

Зарим тогтоол шийдвэрийн биелэлтийн үр дүнгээс дурдвал Аймгийн ИТХ-ын 2014 оны А/55 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласнаар 300 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүд орчин тойрноо камержуулж гэмт хэрэг, зөрчлийг халуун мөрөөр нь илрүүлэн ажиллаж байна. Тухайлбал 2015.10.14-ны өдөр “Рашаан зам” дэлгүүрийн гаднаас иргэн Ц гэч бусдын мотоцикл хулгайлсан хэргийг тус дэлгүүрийн гадна камерын бичлэгээр илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэсэн.

Мөн 2015.06 сард оргил эмийн сангаас О гэч бусдын сүүлийн үеийн загварын 2 төрлийн гар утас, Тариалан сумын харьяат О гэч Орос барааны дэлгүүрээс I PHONE 5 маркын гар утас хулгайлсан гэх хэргүүдийг камерын бичлэгээр илрүүлэн шалгаж амжилттай шийдвэрлэлээ.

2015 оны аймгийн ИТХ-ын 08 дугаар хуралдааны үеэр төлөөлөгч нараас гарсан санал шүүмжлэлийн мөрөөр доорх ажлыг зохион байгуулан ажиллаа.

Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар хамтран ажиллах мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд Увс аймгийн нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд болон бусад байгууллагууд тус тусын үйл ажиллагаанд үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлийн талаар харилцан мэдээлж, болзошгүй аюул, сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар тухай бүрдээ зөвлөлдөн ажиллаж байна.

Аймгийн цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгаас малын үндэсний бүртгэлийн мэдээллийн системд алдагдсан болон олдсон малын талаарх мэдээлэл авах мэдээллийн сангийн бүртгэл хөтөлж байна. Мөн иргэдийг зөв мэдээллээр хангах зорилгоор www.uvs.police.gov.mn сайт, Хархираан цуурай 103.6 Fm, МВС, САМА телевизүүдээр олдсон, алдагдсан малын талаарх мэдээлэл, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил болон үйлдэгдсэн хэргийн талаарх сэрэмжлүүлгийг тогтмол явуулан ажиллаа.

Аймгийн ИТХ-ын ажлын алба, Цагдаагийн газрын мэдээлэл судалгааны албанаас сумдын ГХУСАЗСЗ-д сар бүр аймгийн гэмт хэргийн статистик мэдээг хүргүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа оновчтой төлөвлөн, үр дүнтэй бодитой ажлуудыг хэрэгжүүлэн хийсэн ажлын тайлан мэдээг сар улирлаар ирүүлж байхыг зөвлөж албан үүрэг өгсний дагуу тайлан мэдээг ирүүлэх ажил эрчимжсэн.

Хоёр: Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Дотоодын болон хил дамнансан мал хулгайлах гэмт хэргийн талаар:

2015 оны 03 сард мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Бөхмөрөн, Сагил, Давст, Зүүнхангай, Хяргас, Зүүнговь, Баруунтуруун, Малчин сумдын удирдлагууд, малчид, мал бүхий иргэдтэй хамтарсан уулзалтыг баг бүрд зохион байгуулж сум орон нутгийн онцлог байдалд тулгуурлан малчдын бүлэг нөхөрлөл байгуулан шийдвэрийг ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар албан ёсоор хэлэлцүүлэн баталсан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “ИЛРҮҮЛЭЛТ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2015 оны 04 сарын 10-ны өдрөөс эхлэн “Хаврын нүүдэл” тусгай арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Энэ арга хэмжээг сумдын ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг татан оролцуулж морьт болон мотоциклт эргүүлийг 10 хоногийн хугацаатай 6 ээлжээр ажиллуулснаар иргэдийн 8 тооны бод мал, 24 тооны бог мал хулгайд алдагдахаас урьдчилан сэргийлж, 2 тооны бод мал эзэнд нь хүлээлгэн өгч давхардсан тоогоор 218 айл өрхөд хүрч 280 санамж, сэрэмжлүүлэг тарааж 25 иргэнд тусгайлан хуулийн зөвлөгөө өгсөн үр дүнтэй ажил болж өнгөрлөө.

2015 оны 12 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэгтэй холбогдуулан нийт 72 гомдол мэдээлэл ирснээс 51 иргэний гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 21 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

Мал хулгайлан гэмт хэргээс үүдэлтэй иргэдэд учирсан хохирлыг хэмжээг тооцож үзэхэд иргэдээс гаргасан гомдол мэдээллээр 51 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд 166 тооны бод, 150 тооны бог мал хулгайлагдаж гарсан хохирлын хэмжээ 149,400,000 төгрөг бөгөөд үүнээс нөхөн төлүүлсэн нь 115,300,000 төгрөг бөгөөд гүйцэтгэл 71 хувьтай биелэгдсэн байна.

ОХУ-тай хиллэдэг хилийн бүсийн Тэс, Зүүнговь, Бөхмөрөн, Сагил, Давст, Баруунтуруун сумдын малчид, мал бүхий иргэдтэй тухайн сумын ГХУСЗ, удирдлагуудын хамтарсан уулзалтыг баг бүрээр зохион байгуулж сум орон нутгийн онцлог нөхцөл байдалд тулгуурлан малчдын бүлэг нөхөрлөл байгуулан ажиллаж байна.

2015 оны 3, 9 дүгээр саруудад хилийн бүсийн сумуудаар ХЦ-ийн 0245, 0311 дүгээр ангийн удирдлагууд, аймгийн шүүх, прокурорын байгууллагаас хамтран Бөхмөрөн сумын 1-р багийн 12 айлын төлөөлөл малчидтай уулзалт хийж мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг тарааж малчдын санал бодлыг сонсож 4-6 хот айлыг хамруулсан малчдын 3 бүлэг нөхөрлөл, Сагил суманд 4-9 айл өрхийг хамарсан 10 бүлэг нөхөрлөл, Давст суманд 5-10 айл өрхийг хамарсан 7 бүлэг нөхөрлөл, Баруунтуруун суманд 3-5 айл өрхийг хамарсан 2 бүлэг нөхөрлөл, хилийн бүсийн сумдад шинээр 22 бүлэг нөхөрлөл байгуулан малчдаас бод малаа байнгын хариулга, манаатай байлгаж малаа хулгайд алдахгүй байх талаар бүхий л арга хэмжээ авах үүрэг хариуцлага хүлээдэг талаар тайлбарлан өгч баталгаа гаргуулан авснаар нийт 58 бүлэг нөхөрлөл ажиллаж байна.

Хил дамнасан малын хулгайн зөрчлийг таслан зогсоох чиглэлээр ОХУ-тай хамтран “Хил зөрчигчийг эрж саатуулах үеийн талуудын ажиллагаа” сэдэвт хамтарсан эрлийн сургуулийг зохион байгууллаа.

“Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил авсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комисс”-ын бүрэлдэхүүнийг шуурхай бүрдүүлэн хил залгаа улсын хилийн бүрэн эрхт төлөөлөгчид мэдэгдэж 6 удаагийн хулгайлагдсан малын асуудлыг шийдвэрлэсэн. Мөн малын хулгайн зөрчилд холбогдож байсан болон холбогдож болзошгүй иргэдийн байрлал, тэдгээрийн үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавьж, хилийн цагийн байдлын талаар харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан.

Хамтран ажиллах зөвлөмжийн үр дүнгээр Монгол улсын талаас 9 удаагийн 108 толгой бод мал хил дамнасан хулгайлагдсан, үүнээс 3 удаагийн 31 толгой адууг хил дээр саатуулж, ОХУ-тай хамтарсан эрлийн үр дүнд 1 удаагийн 2, ОХУ-ын талын эрлээр 5 удаагийн 47 толгой адууг олж хилийн уулзалтаар хүлээн авсан.

Хилийн цэргийн 0245-р ангиас хилийн зурваст зөвшөөрөлгүй нэвтэрсэн 5 удаагийн 10 хүн, бэлчээрээр хилд тулсан 18 удаагийн 2865 /бог 1961, бод 904/ толгой малыг тус тус илрүүлж, иргэдэд учирч болох 696.1 сая төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлсэн.

Хил орчмын дэглэм зөрчсөн 19 хүнд Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 535 000 төгрөгийн шийтгэвэр оногдууллаа.

Давст, Бөхмөрөн, Тэс зэрэг хилийн сумдад 6 зөрчил бүртгэгдэж өрх айлын 78 тооны адууг ОХУ-ын талаас хил зөрчин орж ирж хулгайлсан. Өмнөх оны энэ үетэй харьцуулбал малын хулгайн гэмт хэргийн гаралт 5 хувиар өссөн дүнтэй гарсан. Тиймээс дээрх дээрх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр аймгийн ГХУСАЗСЗ-өөс Хилийн тагнуулын алба, Тагнуулын байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Мөн сумдын ИТХ, ЗД нарыг сум орон нутагтаа хилийн болон дотоодын мал хулгайлах гэмт хэргийг бууруулах талаар урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, яриа таниулга явуулах арга хэмжээг нэгдсэн удирдамж гарган хэрэгжүүлэх ажлыг өрнүүлж байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

Хууль зүйн яамнаас 2014 онд архидан согтуурахтай тэмцэх талаар хийсэн ажлын үр дүнг тооцон үнэлж 4 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд олгосонд талархаж байгааг илэрхийлж байна.

Иймд дэмжлэг болгон өгсөн санхүүжилтээр 2015 оны ГХУСАЗСЗ-өөс архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажилласан.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар нь 2015 онд архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр жилийн хугацаанд хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлээ.

Тус төлөвлөгөөнд тусгагдсаны “Архигүй золголт-Архигүй Увс” арга хэмжээний дагууиргэд олон нийтэд архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон архидалтын хор уршгийн талаарх сургалт, сурталчилгааны талаар 1 цагийн шууд нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн САМА телевизээр нэвтрүүлэн ажилласан.

“Архи тамхигүй ажлын байр” шалгаруулах болзолт уралдааны удирдамж боловсруулан 2015.03.05-ны өдрөөс 2015.05.05-ны хооронд 2 сарын хугацаатай зохион байгуулан ажилласан ба арга хэмжээг 2 байгууллагын хамтарсан ажлын хэсэг дүгнэж “Архи тамхигүй ажлын байр” бүрдүүлсэн байгууллага хамт олныг шалгаруулан, Улаангом сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр бөхийн өргөөний гадна төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан 2015.05.29-ны өдөр Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газраас хамтран зохион байгуулсан “Архи тамхигүй ирээдүй” сэдэвт бүх нийтийн арга хэмжээний үеэр шагналыг гардуулсан ба аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шагналыг шийдвэрлүүлэн 1 дүгээр байр эзэлсэн Улаангом сумын 9 дүгээр цэцэрлэгийн хамт олныг хүндэт өргөмжлөл 100 000 төгрөгөөр, 2 дугаар байр эзэлсэн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хамт олныг хүндэт өргөмжлөл 80 000 төгрөгөөр, 3 дугаар байр эзэлсэн Хөдөлмөрийн хэлтсийн хамт олныг хүндэт өргөмжлөл 50 000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулан орон нутгийн САМА, МВС телевизүүдээр иргэд олон нийтэд сурталчлан ажиллаа.

Аймгийн Цагдаагийн газрын алба хаагчдаас 2015 онд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн 32 зөрчлийг илрүүлэн зөрчил гаргагч нарт 2 220 000 төгрөгийн торгууль оногдуулж, 184 литр архи, 95 литр пиво хураан авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, аймгийн Засаг даргаас тогтоосон сар бүрийн 1-ний өдөр архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэхийг хориглосон заалтыг зөрчсөн 7 зөрчлийг илрүүлэн 56 000 төгрөгийн торгууль оногдуулж орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажиллаа.

Дээрх дэмжлэг болгон олгосон 4 сая төгрөгөөс аймгийн цагдаагийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх ажилд техникийн дэвшлийг бүтээлчээр ашиглах, гэмт хэрэг илрүүлэлтийг шуурхай болгох, таслан зогсоох, бартаа саадтай газрыг богино хугацаанд тогтоох ач холбогдол бүхий “Нисдэг камер”-ийн төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд гарах нийт 4 920 000 төгрөгийн техник худалдан авах зардлыг аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсвөөс шийдвэрлэлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “Хархираан цуурай-103.3” радиотой хамтран жолооч, зорчигч нарт замын хөдөлгөөний дүрмийн 2.7.а дахь заалт “согтуугаар ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх”, 2.3.а дахь заалт “хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах”, 2.3.б дэх заалт “Хамгаалах бүс хэрэглэх”, 2.3.в дэх заалт “мотоцикл жолоодохдоо хамгаалах малгай хэрэглэх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх”, 13.1 дэх заалт “явган хүний гарцаар гарч байгаа хүнд зам тавьж өгөх” гэсэн заалтуудаар шторк сурталчилгааг нэвтрүүлэн хамтран ажилласнаар иргэд, жолооч нарын зам хөдөлгөөний соёлд ахиц гарч байна. Монгол Улсын Их Хурлаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэчилсэн хууль шинэчлэн батлаж 2015 оны 09-р сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой хуулийг дагаж мөрдөх хууль зөрчсөн жолооч нарт хүлээлгэх хариуцлагын талаар иргэд олон нийтэд орон нутгийн МВС, САМА, Увс телевизээр мэдээл, мэдээлэл хийж ажилласан. Мөн

хөдөө орон нутгийн иргэдэд хуулийг сурталчлах, сургалт зохион байгуулахаар хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт сургалтын DVD материал хүргүүлж хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаа. Зам тээврийн осол хэргийг сурталчилах, түүнээс үүдэн гарах хор хохирлыг иргэд, олон нийтэд танилцуулах, шинэчлэн батлагдсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн хууль зүйн хэлтэстэй хамтран орон нутгийн “Увс” телевизээр “Хуулийн цаг” нэвтрүүлэг бэлтгэн сурталчлан ажиллаа.

2015 оны 07 сарын 08-нд шинэчлэн батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүднээс зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна

Мөн аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд багачуудад замын хөдөлгөөнд оролцох зөв дадал, мэдлэг, хандлага төлөвшүүлэх зорилгоор School Police арга хэмжээг улирал бүр зохион байгуулж хүүхдүүдийг зам хөндлөн гарах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлгөөнд оролцсон жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг мөрдөх дадалд хэвшүүлэх үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллаа.

Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргийн талаар:



Увс аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулах салбар зөвлөлөөс шүүх, прокурор болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж тус зөвлөгөөнөөр Увс аймагт “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг ярилцаж цаашид хүчирхийллийг бууруулах, тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай нэгдсэн

зөвлөмж гаргав. Зөвлөмжид хүчирхийлэлд өртөгсдөд зөвлөгөө өгөх ажлыг тогтворжуулах, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах, хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, сумын цагдаагийн ажилтнаас идэвх гаргаж илрүүлдэг гуравдагч сувгийг нээх тал дээр анхаарахыг тусгалаа.

Өсвөр насны хүүхдийн эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх нь хэлэлцүүлгийг Аймгийн Иргэний танхимтай хамтран насанд хүрэгчид, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн дунд зохион байгууллаа. Хэлэлцүүлэг НХХэлтэс, БСГ, ЦГ, ЕБС-дын нийгмийн ажилтнууд, Шашны байгууллагын төлөөлөл, иргэдийн төлөөлөл 43 хүн оролцлоо. Хэлэлцүүлгээр өсвөр насны хүүхдүүдийн эрсдэлт зан үйлд нөлөөлж буй асуудлуудыг тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх арга зам, орон нутгийн түвшинд бид юуг анхаарах талаар голлон ярилцлаа.

Хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах урьдчилан сэргийлэх нөлөөллийн “Хамтдаа сэргийлцгээе”, “Хариу нэхээгүй тус”, “Хуулийн мэдээлэл” 3 төрлийн ажлыг Хууль зүйн хэлтэс, Цагдаагийн газрын Хүүхдийн алба, Аймгийн Прокурорын газар, Хүний эрхийн салбар зөвлөлтэй хамтран 160 насанд хүрэгчид,

2360 гаруй хүүхдэд эрх, үүргийн талаар нээлттэй өдөрлөг зохион байгуулан мэдээллээр хангаж ажиллалаа. Ингэснээр хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, ээлтэй орчин бүрдэж гэр бүлийн хүчирхийлэл буурах хандлагыг бий болголоо.

Хүүхэд хамгааллын хамтарсан баг"- ийн үйлчилгээнд хамрагдсан 1860 хүн 6570 гаруй хүүхэд, зорилтод бүлгийн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 13 кэйс үйлчилгээнд хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан нь хамгааллын талаарх нөлөөллийн ажил эрчимжсэн. Гэр бүлийн хүчирхийлэл дарамтад буй хүүхдийг судлан хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалахад чиглэсэн ажлыг 2 үе шаттай 3 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулснаар эрх зөрчигдсөн 16 хүүхэдтэй нэг бүрчлэн ажилласан.

Гэмт хэрэгт өртсөн, өртөж болзошгүй гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийг бүртгэх зорилгоор бүртгэлийн дэвтрийг нээн ажиллуулж, мэдээллийн санг баяжуулан ажилласны үр дүнд нөлөөллийн 8 төрлийн ажлыг зохион байгуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, "Хууль ба эрсдэл", "Хүүхэд хамгаалал" 3 төрлийн зөвлөмж, 2 төрлийн хэлэлцүүлэг, 3 төрлийн арга хэмжээ зохион байгуулан ажилласнаар урьдчилан сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдлээ.

Гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг ерөнхий боловсролын сургуулиудын судалгааг нэрчилэн гаргаж, Цагдаагийн Хүүхдийн алба, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Улаангом сумын ГХУСЗЗА-тай хамтран зөвлөн туслах 3 төрлийн 6 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан нь гэмт хэргийн эрсдэлээс хамгаалагдаж чадсан.

Аймгийн хэмжээнд "Хүүхдийн найз утас -70452525" -ны талаар үе шаттай 3 удаагийн 9970 хүүхэд, 13290 насанд хүрэгчдийг хамруулсан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан гэмт хэргийн талаар зөвлөгөө мэдээллээр гэр бүлийн хүчирхийлэл дарамтад буй хүүхдийн талаар эрх ашиг нь зөрчсөн гэх зориулалтын 69 дуудлага ирж 19 дуудлагын дагуу холбогдох газарт шилжүүлэн гомдлыг шийдвэрлүүллээ.

Төлөвлөгөөт ажлын хүрээнд архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 2015 эхний хагас жилийн байдлаар дараах ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаа.

Гурав: ГХУСАжлын талаар олон нийтийн хамарсан арга хэмжээ:



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гарын авлага болгон сурталчлах шторк, кейс, зурагт хуудас шалгаруулах уралдаан, Монгол улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөл, Боловсрол, соёлын газар хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд "Шинэ үндсэн хууль ба иргэний журамт үүрэг" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, "Ажлын байран дахь архи, тамхигүй байгууллага" хамт олныг шалгаруулах болзолт уралдааныг тус тус зарлаж байр эзлүүлэн шалгарсан байгууллага, алба хаагчдыг аймгийн ГХУСАЗСЗ-өөс шагнаж урамшууллаа.

“Сургуулийн цагдаа” арга хэмжээний хүрээнд :



“School police” арга хэмжээ эхэлснээр Улаангом сумын ЕБ-ын 7 сургуулийн 1-р ангийн нийт 29 бүлгийн 529 эцэг эх 54 өдөр эргүүл хийсэн бөгөөд цаашид Аймгийн ИТХ-ын даргын өгсөн үүрэг даалгаварын дагуу мэргэжилтэн И.Ганболд энэ ажлыг өргөжүүлэн чанаржуулахад сургуулийн холбогдох ажилтнуудтай хамтран ажиллаж 2-3-р ангийн сурагчдын эцэг эхчүүдийн эргүүлээр үргэлжилж байна. Энэхүү ажил хэрэгжсэнээр сурагчдад учирч болох зам тээврийн осол гэмтлийг бууруулах, арилгах, явган хүний гарц, гармаар гарах дадал хэвшлийг суулгахад тодорхой үр дүн өглөө.

“Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээн:

Аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Улаан загалмайн хороо, Боловсрол, соёлын газраас хамтран Улаангом сумын ЕБ-ын 7 сургуулийн 3-5-р ангийн сурагчдын дунд замын хөдөлгөөн аюулгүй байдлын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилготой “Ногоон гэрэл, цагаан шугам” уламжлалт тэмцээн 2015 оны 11 сарын 1-нд зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд Цогцолбор 1, Ахлах 3, Ахлах 4, Чандмань эрдэм сургуулийн 4 багийн 50 сурагч, 5 багш оролцов. Энэ ажлын хүрээнд зам тээврийн аюулгүй байдлын чиглэлээр сургуулиудын зохион байгуулсан ажлууд, сурагчдын дунд зохион явуулсан сургалт, сурталчилгааны талаар тайлан танилцуулга хийгдсэн байна. Хариуцсан мэргэжилтэн энэхүү арга хэмжээнд оролцсон бөгөөд тэмцээний өргөмжлөл, медалиудыг бэлтгэж ивээн тэтгэсэн. Энэ ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгүүд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой орчин нөхцөл бүрдүүлэн ажиллаа.

Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, сурталчилгаа



2014 онд өндөр үзүүлэлттэй гарсан гэмт хэрэгт анхаарч ажиллах үүднээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр агуулгын сургалтуудыг ЕБС-ын сурагчдыг хамарсан-8, олон нийтийг хамарсан-7 төрлийн давхардсан тоогоор нийт 21 удаагийн сургалт, 8 мэдээлэл сурталчилчилгааны ажлыг тус тус зохион байгууллаа.

ЕБС-ийн сурагчдад хүүхдийн эрх хамгаалал, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт сурталчилгааг тодорхой хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна. Үүнд:

- Аймгийн төвийн 6 сургуулийн 6-7 ангийн нийт-27 сурагч, Тэс, Малчин, Зүүнговь, Наранбулаг, Завхан, Өлгий, Тариалан сумын 6 ангийн 420 гаруй сурагчдад “Хүүхдийн эрх, үүрэг”-ийн тухай
- Бага ангийн 3-5-р ангийн “Хүн нийгэм” хичээлийн хөтөлбөрт тусгагдсан “Замын хөдөлгөөн” бүлэг сэдвийн хүрээнд замын хөдөлгөөний анхан шатны мэдлэг ойлголтэээмшүүлэх тухай
- 1-5-р ангийн сурагчдад “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн тухай
- Насанд хүрээгүй этгээдээс үйлдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн сургалт үе шаттайгаар
- Хууль зөрчсөн хүүхдэд хорихоос өөр нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийг хамт олонд түшиглэсэн нийгэмшүүлэх хүмүүжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор эцэг, эхэд хүүхдэд тусгайлан зөвлөгөө
- Насанд хүрээгүй этгээдээс үйлдсэн, үйлдэж болзошгүй хэргийн хор уршигийн талаар 2 төрлийн мэдээлэл, 2 зөвлөмжийг нийт 80 өрх гэр бүл, 1620 насанд хүрэгчид
- Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийн хүрээнд 1260 насанд хүрэгч 12630 хүүхдэд
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци эрх зүйн баримт бичгийг олон нийтэд хүргэх зорилгоор тамхи мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдээллийн LD телевиз, EM, facebook–ээр тус туссургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай зохион байгуулснаар хүүхэд гэр бүл ёс суртахууны эсрэг гэмт хэргийг бууруулах хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, гарын авлага материалаар хангах ажлыг идэвжүүлэн ажиллаа.

Иргэд олон нийтэд чиглэсэн дараах арга хэмжээг зохион байгуулаа.

ГХУСАЗСЗ-ийн ажлыг хууль сахиулах байгууллага болон бусад хяналт шалгалтын байгууллага, иргэдтэй хамтран бүх нийтэд хүртээмжтэй ажиллахын тулд гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах итгэлтэй утас **1800-1505, 109**, Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны **7045102, 93020302** үүрэн телефоны суурин утас байнгын хамтарч ажиллаж байна.

- ✚ Монгол улсын Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газруудын хамтран бэлтгэж ирүүлсэн хар тамхины гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтан алба хаагчдаас иргэд олон нийтэд санамж болгон байршуулан сурталчлах
- ✚ Хилийн зурваст нутагладаг айл өрхүүдэд хил дамнасан малын хулгайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор тангуул, цагдаагийн байгууллага, хилийн сумдын ЗДТГ-тай хамтран хил орчмын иргэдэд 4 удаа хууль сурталчилан ухуулга яриа хийх
- ✚ Иргэдийг хил хамгаалалтад татан оролцуулах журам, хилийн тухай хуулийн холбогдох заалтуудаар 14 удаагийн 219 хүнд 48 цагийн сургалт
- ✚ Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт эрхлэх ажлын хүрээнд ГХУСАжлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллах, сургалт мэдээллээр иргэдийг тасралтгүй хангах, харилцан хамтран ажиллах талаар зөвлөмж

- ✚ Иргэдийн өмчийн хулгайтай тэмцэх зорилгоор “Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “байгууллага, аж ахуйн нэгжүүд орчин тойрноо камержуулах” талаарх аймгийн ИТХ-н 2014 оны А-55 тоот тогтоол, уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах агуулга бүхий аймгийн Засаг даргын 2015.01.26-ны өдрийн А-25 тоот захирамжийг сурталчилсан 2 төрлийн шторк
- ✚ Хилийн зурваст нутагладаг айл өрхүүдэд хил дамнасан малын хулгайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор 4 удаа хууль сурталчлах

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2015 оны 1-3 дүгээр улиралд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээнд үндэслэн өсөлттэй болон анхаарал татсан тодорхой төрлийн гэмт хэргүүдийн гаралт, түүний шалтгаан нөхцлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа танилцуулга хийж ажилллаа. Тус сургалт мэдээлэлд Тариалан сумын 87 иргэн, Наранбулаг сумын 34 иргэн, Завхан сумын 58 иргэн, Өлгий сумын 67 иргэн, Өмнөговь сумын 63 иргэн, Ховд сумын 53 иргэн, Бөхмөрөн сумын 31 иргэн нийт 393 иргэн хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн үр дүнтэй мэдээлэл боллоо.

Дүгнэлт:

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015 оны ажлын зорилт төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд 91 хувийн гүйцэтгэлтэй биелэгдсэн бөгөөд үорилт болгон хэрэгжүүлэхээр тавьсан ажил үйлчилгээ бүрэн хийгдсэн билээ. Аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн төсөв нь орон нутгийн торгууль, шийтгэвэрийн орлогоос хамааран төлөвлөгддөг зарим үйл ажиллагаа зардал мөнгөний улмаас хэрэгжихгүй хойшлогдох хийгдэхгүй үлдэх асуудал жил бүр тулгамдсаар байна.

2016 онд аймгийн ГХУСАЗСЗ-ийн гишүүд болон зарим сумын ГХУСАЗСЗ-ийн идэвхи санаачлага гарган сайн ажилласан байгууллага, албан тушаалтныг шагнаж урамшуулах, мөн тухайн ажил хариуцсан албан тушаалтныг чадавхжуулах сургалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаарх асуудалд анхаарч бидэнтэй хамтарч ажиллах ажлын саналыг хүлээн авч шийдвэрлэж өгөхийг уламжилж байна.

Хуудсын тоо-14

ХЯНАСАН:

АЙМГИЙН ГХУСАЗСЗ-ИЙН ДАРГА

Ч.ЧИМЭД

ТАЙЛАН БИЧСЭН:

ГХУСАЗСЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.ЭНХЖАРГАЛ

